



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/5/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: Bulgan@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Цэдэнлхам Утас:9982-8263 Цахим хаяг: Tsedenkham@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.24 № 849
танай _____ ны № _____ т

ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТАМГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.БАТЖАРГАЛ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Прокурорын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Прокурорын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/11 дүгээр тушаалын 1,2 дугаар хавсралтаар 4 нэр төрлийн 12.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэн авсан байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 763 дугаар тогтоол, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Улсын ерөнхий прокурорын А/08 дугаар тушаалыг үндэслэн 17 нэр төрлийн 38 ширхэг

6328050327

16.5 сая төгрөгийн тавилга, эд хогшил, машин тоног төхөөрөмжийг акталж устгасан байна.

Бусад асуудлын хэсэг

“Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-г хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд системийн хөгжүүлэлтийн ажлыг хийж, нэгдсэн системийн хэрэглэгч 161 эрх бүхий албан тушаалтанд зориулсан сургалтыг амжилттай зохион байгуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.БАТЦОГТ



Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	48,076.0	36,315.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	557,790.4	481,959.5
Нийт хөрөнгийн дүн	605,866.4	518,274.5
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	605,866.4	518,274.4
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	605,866.4	518,274.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,630,425.9	1,632,730.5
Үйл ажиллагааны зардлын дүн	1,320,668.6	1,720,322.5
Үйл ажиллагааны үр дүн	309,757.3	(87,592.0)
Үйл ажиллагааны бус үр дүн	(863.6)	
Үйл ажиллагааны нийт үр дүн	308,893.7	(87,592.0)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,972.7	605,866.4
Тайлант оны үр дүн	308,893.7	(87,592.0)
Эцсийн үлдэгдэл	605,866.4	518,274.4
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,263,233.5	1,619,859.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,266,233.5	1,619,859.8
Үйл ажиллагааны ЦМГ	(3,000.0)	-
Хөрөнгө оруулалтын ЦМГ		
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(3,000.0)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,000.0	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,165,880.4	1,530,109.6
Урсгал зардал	1,165,880.4	1,530,109.6
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,261,233.5	1,530,109.6
Улсын төсвөөс санхүүжих	1,261,233.5	1,530,109.6
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Прокурорын газар нь Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналт, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт, Шүүхэд төрийг төлөөлөх, Төр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Монгол улсын прокурорын байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөнд дараах зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлнэ.
2. Прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангана.
3. Прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгоно.
4. Хамт олны дунд эерэг хандлагыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг сайжруулна.
5. Цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Прокурорын газрын 2025 онд хийх гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр баталсан бөгөөд 36 арга хэмжээг хийхээр төлөвлөж, давхардсан тоогоор нийт 60 арга хэмжээг хийж гүйцэтгэн, Улсын ерөнхий прокурорын газрын даргаар 98.0 хувьтай үнэлүүлэн “маш сайн” үнэлгээ авсан байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Прокурорын нь үйл ажиллагаандаа Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Прокурорын тухай, Зөрчлийн тухай, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга;
- Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Сангийн сайдын холбогдох журам зааварт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, “Төсвийн сахилга бат, хариуцлагыг

чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

“Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-г хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд системийн хөгжүүлэлтийн ажлыг хийж, нэгдсэн системийн хэрэглэгч 161 эрх бүхий албан тушаалтанд зориулсан сургалтыг амжилттай зохион байгуулсан байна.

Тав. Аудитын гол асуудал

Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/11 дүгээр тушаалын 1,2 дугаар хавсралтаар 4 нэр төрлийн 12.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэн авсан байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 763 дугаар тогтоол, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Улсын ерөнхий прокурорын А/08 дугаар тушаалыг үндэслэн 17 нэр төрлийн 38 ширхэг 16.5 сая төгрөгийн тавилга, эд хогшил, машин тоног төхөөрөмжийг акталж устгасан байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс хугацаа болоогүй 5 мэдээлэл байна. 177 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, Байгууллагын батлагдсан төсөв” мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 1,805.2 сая төгрөгийн 13 орлогын, 38.5 сая төгрөгийн 3 зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж ажилласан байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 0.3 сая төгрөгийн алдаа, зөрчил¹ илэрснээс 0.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоолоо.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 0.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 17.6 сая төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Төлбөрийн акт

1. Төрийн захиргааны алба хаасан хугацааны нэмэгдлийг 1 албан хаагчид үндэслэлгүйгээр 0.3 сая төгрөгийг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам" зөрчсөн нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү тооцож олгосон.	1	0.3	1	0.3								
Дүн	1	0.3	1	0.3	-	-	-	-				